

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

МАНДАЛ ДААТГАЛ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

### Аудиторын дүгнэлт

Бид Мандал Даатгал ХК (цаашид “Компани” гэх)—ийн 2024 оны 12 дугаар сарын 31—ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31—ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (“НББОУСЗ”)—өөс гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)—ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)—уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”—ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

### Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС—ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Компанийн удирдлага нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

### Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч “АОУС”—ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.



## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

### Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг (үргэлжлэл)

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг Компанийн удирдлагад мэдэгддэг.

### Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор бус, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно

## НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид:



Улаанбаатар хот, Монгол улс  
Огноо: 2025 оны 2 дугаар сарын 25

  
У.НАРАНДЭЛГЭР  
Аудитор




## МАНДАЛ ДААТГАЛ ХК

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН  
АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	2024	2023
Даатгалын орлого	34,922,834	24,592,395
Даатгалын үйлчилгээний зардал	(23,953,002)	(18,280,237)
Даатгалын үйлчилгээний үр дүн	10,969,832	6,312,158
Давхар даатгалын орлого / (хураамжийн төлөлт)	291,762	370,942
Давхар даатгалаас хүлээн авсан нөхөн төлбөр	1,373,246	2,997,402
Давхар даатгалын цэвэр үр дүн	1,665,008	3,368,344
Даатгалын үйлчилгээний цэвэр үр дүн	12,634,840	9,680,502
Хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгийн хүүний орлого	8,596,354	5,790,980
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх хөрөнгө оруулалтын цэвэр олз	149,459	1,236,837
Хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн олз	154,912	149,388
Санхүүгийн хөрөнгө, гэрээний хөрөнгийн үнэ цэнийн бууралтын өөрчлөлтөөс үүссэн олз, гарз (үнэ цэнийн бууралтын буцаалтыг оруулсан)	(1,096,247)	4,137
Цэвэр хөрөнгө оруулалтын орлого	7,804,478	7,181,342
Бусад олз / (гарз)	362,074	665,763
Бусад үйл ажиллагааны зардал	(11,527,265)	(10,608,594)
Бусад санхүүгийн зардал	(95,647)	(120,670)
Татварын өмнөх ашиг	9,178,480	6,798,343
Орлогын албан татварын зардал	(846,696)	(708,275)
Тайлант жилийн цэвэр ашиг	8,331,784	6,090,068
Бусад дэлгэрэнгүй орлого	142,911	(237,115)
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого	8,474,695	5,852,953
Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (төгрөгөөр)	13.57	9.38

Тодруулга "Тайлан бэлтгэх үндэслэл": Хураангуй санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Компанийн санхүүгийн тайлангуудаас өөрчлөлөггүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.



## МАНДАЛ ДААТГАЛ ХК

### 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	2024.12.31	2023.12.31
<b>ХӨРӨНГӨ</b>		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,371,402	14,172,386
Санхүүгийн хөрөнгө	67,697,766	36,389,403
Хорогдуулсан өртгөөр бүртгэх	60,024,634	28,804,237
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх	3,373,254	2,989,600
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх	4,299,878	4,595,566
Даатгалын гэрээний хөрөнгө	2,978,029	4,733,085
Давхар даатгалын гэрээний хөрөнгө	3,646,721	1,196,720
Авлага	532,508	690,685
Урьдчилж төлсөн төлбөр, тооцоо ба бусад хөрөнгө	351,913	406,864
Бараа материал	23,737	41,772
Борлуулалтын зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	2,776,701	600,438
Үндсэн хөрөнгө	1,031,407	1,154,995
Ашиглах эрхтэй хөрөнгө	399,957	1,005,304
Биет бус хөрөнгө	105,226	173,445
Нийт хөрөнгө	80,915,367	60,565,097
<b>ӨР ТӨЛБӨР</b>		
Даатгалын гэрээний өр төлбөр	30,299,657	20,531,548
Давхар даатгалын гэрээний өр төлбөр	3,782,391	1,368,849
Дансны ба бусад өр төлбөр	1,832,650	1,383,240
Орлогын албан татварын өр төлбөр	91,718	281,692
Хойшлогдсон татварын өр төлбөр	156,041	156,041
Түрээсийн өр төлбөр	375,927	941,439
Нийт өр төлбөр	36,538,384	24,662,809
<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>		
Хувьцаат капитал	6,243,016	6,243,016
Нэмж төлөгдсөн капитал	4,441,896	4,441,896
Тусгай нөөц сан	1,256,290	1,256,290
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц сан	223,933	81,022
Хуримтлагдсан ашиг	32,211,848	23,880,064
Эздийн өмч	44,376,983	35,902,288
Нийт эздийн өмч ба өр төлбөр	80,915,367	60,565,097

*Тодруулга "Тайлан бэлтгэх үндэслэл": Хураангуй санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Компанийн санхүүгийн тайлангуудаас өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.*

МАНДАЛ ДААТГАЛ ХК

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ  
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц сан	Тусгай нөөц сан	Хуримтлагд- сан ашиг**	Нийт
2023 оны 1 сарын 1-ээрх	6,243,016	4,441,896	318,137	1,256,290	17,789,996	30,049,335
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	(237,115)	-	6,090,068	5,852,953
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
2023 оны 12 сарын 31-ээрх	6,243,016	4,441,896	81,022	1,256,290	23,880,064	35,902,288
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	142,911	-	8,331,784	8,474,695
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
2024 оны 12 сарын 31-ээрх	6,243,016	4,441,896	223,933	1,256,290	32,211,848	44,376,983

Тодруулга "Тайлан бэлтгэх үндэслэл": Хураангуй санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Компанийн санхүүгийн тайлангуудаас өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.



## МАНДАЛ ДААТГАЛ ХК

### 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	2024	2023
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
Татварын өмнөх ашиг	9,178,480	6,798,343
<i>Татварын өмнөх ашгийг цэвэр мөнгөн гүйгээтэй тохируулах мөнгөн бус тохируулгууд:</i>		
Үндсэн хөрөнгийн элэгдэл	368,189	506,210
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл	619,146	327,336
Биет бус хөрөнгийн хорогдол	68,219	74,329
Хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгийн хүүний орлого	(8,749,101)	(5,790,980)
Өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх хөрөнгө оруулалтын олз	382,596	(1,136,428)
Хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн олз	(239,685)	(149,388)
Хүүний зардал	95,647	(105,768)
Үндсэн хөрөнгө борлуулснаас олсон (олз) / гарз	(5,523)	(306,678)
Ханшийн бодит бус (олз) / гарз	(806)	106,428
Үндсэн хөрөнгө данснаас хассан зардал	24,011	-
Ногдол ашиг	(141,103)	100,410
<b>Ажлын капиталын өөрчлөлт</b>	1,600,070	423,814
Авлагын бууралт/(өсөлт)	2,472,730	3,960,947
Бараа материалын бууралт / (өсөлт)	18,035	71,126
Урьдчилж төлсөн төлбөр, тооцооны өсөлт	54,951	(209,754)
Хойшлогдсон даатгалын орлогын шимтгэлийн зардлын өсөлт / (бууралт)	(884,169)	(429,158)
Давхар даатгагчид ногдох даатгалын нөөц (өсөлт) / бууралт	(4,819,871)	(17,120,949)
Даатгалын нөөц сангийн (өсөлт) / бууралт	(18,727,308)	22,323,937
Хойшлогдсон даатгалын шимтгэлийн орлогын (бууралт) / өсөлт	328,805	(108,744)
Дансны болон бусад өглөгийн өсөлт/(бууралт)	(757,243)	(4,095,196)
<b>Үйл ажиллагаанаас олсон мөнгө</b>	(20,714,000)	4,816,023
Төлсөн хүү	(95,647)	(105,048)
Төлсөн татвар	(1,036,670)	(390,471)
<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	(21,846,317)	4,320,504
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
Үндсэн хөрөнгийн худалдан авалтад зарцуулсан	(207,195)	(242,143)
Биет бус хөрөнгийн худалдан авалтад зарцуулсан	-	(83,600)
Санхүүгийн хөрөнгө оруулалтаас хүлээн авсан / (олгосон)	2,813,886	4,130,382
Түрээсийн сайжруулалтад зарцуулсан	-	(401,682)
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийн борлуулалтаас хүлээн авсан	264,626	310,000
Үндсэн хөрөнгийн борлуулалтаас хүлээн авсан	19,243	267,319
Хүлээн авсан хүү	6,641,903	5,647,917
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	9,532,463	9,628,193
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
Түрээсийн төлөлт	(487,936)	(707,548)
Ногдол ашгийн төлөлт	-	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	(487,936)	(707,548)
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт / (бууралт)</b>	(12,801,790)	13,241,149
Ханшийн зөрүүний нөлөө	806	(106,428)
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	14,172,386	1,037,665
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	1,371,402	14,172,386

*Тодруулга "Тайлан бэлтгэх үндэслэл": Хураангуй санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Компанийн санхүүгийн тайлангуудаас өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.*

